



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/643

Улаанбаатар хот

Индекс шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3, 2.1.4, 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт, “Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрэм”-ийн 7.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1. Байгууллагын зохион байгуулалт, бүтцийн нэгжид олгох хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын индексийг 1 дүгээр хавсралтаар, хэвлэмэл хуудасны индексийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдлагын үйл ажиллагааг баримтжуулах болон албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд батлагдсан индексийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж ажиллахыг байгууллагын нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023 оны А/22 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2025 оны 12 дугаар сарын 24-ны
өдрийн 10.1р тушаалын нэгдүгээр хавсралт

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖИД
ОЛГОХ ХӨТЛӨХ ХЭРГИЙН НЭРИЙН
ЖАГСААЛТЫН ИНДЕКС

Д/д	Индексийн дугаар	Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэр
1	01	Захиргаа удирдлагын хэлтэс
2	02	Өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс
3	03	Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс
4	04	Хууль зүйн хэлтэс

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2025 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ...-р тушаалын хоёрдугаар хавсралт

ХЭВЛЭМЭЛ ХУУДАСНЫ ИНДЕКС

Д/д	Индексийн дугаар	Хэвлэмэл хуудасны төрөл	Тайлбар
1	1425010000	Тушаал	14-бүсчлэлийн код (СБД), 25-2025 он
2	1425020000	Албан бичиг А/4	
3	1425030000	Албан бичиг А/5	
4	1425040000	Албан даалгавар	
5	1425050000	Хурлын тэмдэглэл	
6	1425060000	Мэдэгдэх хуудас	